



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 07 сарын 19 өдөр

Дугаар A/131

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Мөнххайрхан сумын төвөөс аймгийн төв хүртэлх 65 км замын засвар, Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх замын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Б.Баярсүх	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Гишүүд:	Ц.Даваасамбуу	-Орон нутгийн өмчийн газрын өмчийн ахлах мэргэжилтэн
	Н.Жавзанханд	- Төрийн бус байгууллагын төлөөлөл
	П.Эрдэнэ-очир	- Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

X.Дэмид	-Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
---------	---

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо / Б.Баярсүх /-нд үүрэг болгосугай.

3. Дээрх төсөлт арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Х.Дэмид /-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД



2019 тг A/131 Ch
02 00602